



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг  
ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн хураангуй тайлан, төсвийн  
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **ӨВА-2025/013/НА-СТА-ОНӨҮГ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Өвөрхангай аймаг,  
Арвайхээр сум  
2025 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал  
Утас: 70323253 Цахим хаяг: batjargalo@audit.gov.mn  
Аудитын менежер: П.Хорлоосүрэн  
Утас: 70323108 Цахим хаяг: khorloosuren@audit.gov.mn  
Аудитор: Р.Мягмарсүрэн  
Утас: 70323833 Цахим хаяг: myagmarsuren@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,  
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 133  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

“АРВАЙХЭЭР ХОТЫН НИЙТИЙН  
ТЭЭВЭР ГЭРЭЛТҮҮЛЭГ” ОНӨААТҮГ-ЫН  
ДАРГА Х.ЭНХЖАРГАЛ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Арвайхээр сумын Нийтийн тээвэр гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Арвайхээр хотын нийтийн тээвэр гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Мөнгөн хөрөнгийн харилцах данснаас 66.3 сая төгрөгийн шатахууны гүйлгээг И-баримтгүй шилжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6. "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн хуулийн заалтууд, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар"-ын 6.5. Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана, Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

6225020116

нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" гэж заасантай нийцээгүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан зүйлсийн хувьд тайлант онд орон нутгийн төсвөөс 538.9 сая төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлогоос 81.1 сая төгрөг оруулж, 559.6 сая төгрөгийн зардал гаргаж харилцах дансанд 47.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

#### **Аудитын гол асуудал**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно. Тайлант онд цалингийн зардалд 234.3 сая төгрөг, түлш шатахууны зардалд 73.5 сая төгрөгийн зардал гаргасан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

**1.Хараат бус аудиторын дүгнэлт**

**2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>29588054.78</u></b>	<b><u>26896801.65</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	1599504.78	47971.65
<b>311</b>	<b>Кассад байгаа бэлэн мөнгө</b>	50.00	50.00
31110	Төгрөг	50.00	50.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	1599454.78	47921.65
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	1599454.78	47921.65
31213	Арилжааны банк дахь харилцах	1599454.78	47921.65
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	27,988,550.00	26,848,830.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	5950800.00	4811080.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	22037750.00	22037750.00
35410	Бичиг хэргийн материал	195250.00	195250.00
35420	Аж ахуйн материал	14860500.00	18784500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	6982000.00	
35450	Барилгын засварын материал		3058000
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>705858691.14</u></b>	<b><u>759697310.66</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	705858691.14	759697310.66
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	705858691.14	759697310.66
39203	Авто-тээврийн хэрэгсэл	523415172.00	597915172.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-318019732.14	-376264337.05
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	28889900.00	28259900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-27628750.14	-25751199.92
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1986954.00	2997254.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1986954.00	-901837.32
39209	Зам, гүүрийн байгууламж	86782230.00	86782230.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-53274464.88	-69958644.72
39214	Бусад үндсэн хөрөнгө	1855926580.28	2160602003.28
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1390232243.98	-1643983229.61
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>735446745.92</u></b>	<b><u>786594112.31</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>735446745.92</u></b>	<b><u>786594112.31</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	735446745.92	786594112.31
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	735446745.92	786594112.31
51210	Өмнөх үеийн үр дүн	1062388547.42	735446745.92
51220	Тайлант үеийн үр дүн	-326941801.50	51147366.39
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>735446745.92</u></b>	<b><u>786594112.31</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b><u>477555781.71</u></b>	<b><u>1084258571.29</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b><u>477555781.71</u></b>	<b><u>1084258571.29</u></b>

Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	477555781.71	1084258571.29
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	477555781.71	620,048,148.29
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	383619800.00	538,918,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	93935981.71	81,129,748.29
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	321,410,423.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	142,800,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>804497583.21</b>	<b>1033111204.90</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>804497583.21</b>	<b>1033111204.90</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	804497583.21	1030575704.90
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	144158604.00	234336220.86
210101	Үндсэн цалин	144158604.00	234336220.86
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	17789921.44	29473121.13
210201	Тэтгэврийн даатгал	17789921.44	29473121.13
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	94007840.00	116143848.00
210301	Гэрэл, цахилгаан	91607840.00	115743848.00
210304	Байрны түрээс	2400000.00	400000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	88405750.00	96612110.00
210401	Бичиг хэрэг	4536600.00	656900.00
210402	Тээвэр, шатахуун	62647600.00	73424050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	528000.00	660000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20693550.00	21871160.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2200000.00	19871000.00
210604	Урсгал засвар	2200000.00	19871000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	0.00	240000.00
210702	Дотоод албан томилолт	0.00	240000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4518829.17	4425431.43
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	570000.00	1568000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1200000.00	1650000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	318000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2513500.00	330000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	132000.00	46000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	440000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	103329.17	73431.43
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	453416638.60	529473973.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	86949260.00	199947170.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	366467378.60	329,526,803.48
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	0.00	2535500.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	0.00	2535500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	2535500.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-326941801.50</b>	<b>51147366.39</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-326941801.50</b>	<b>51147366.39</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>477555781.71</b>	<b>620048148.29</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>477555781.71</b>	<b>620048148.29</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	477555781.71	620048148.29
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	477555781.71	620048148.29
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	383619800.00	538918400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	93935981.71	81129748.29
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>457564736.61</b>	<b>559644681.42</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>457564736.61</b>	<b>559644681.42</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>457564736.61</b>	<b>557109181.42</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	143783446.00	234336220.86
210101	Үндсэн цалин	143783446.00	234336220.86
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	17789921.44	29473121.13
210201	Тэтгэврийн даатгал	17789921.44	29473121.13
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	94007840.00	116143848.00
210301	Гэрэл, цахилгаан	91607840.00	115743848.00
210304	Байрны түрээс	2400000.00	400000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	76977850.00	74890150.00
210401	Бичиг хэрэг	4519800.00	660500.00
210402	Тээвэр, шатахуун	67623450.00	71783350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	528000.00	660000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4306600.00	1786300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	0.00	4219600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	4219600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	114180850.00	38532200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4409000.00	1245000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1096000.00	0.00
210604	Урсгал засвар	108675850.00	37287200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	0.00	240000.00
210702	Дотоод албан томилолт	0.00	240000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4518829.17	4530431.43
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	570000.00	1673000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1200000.00	1650000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	318000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2513500.00	330000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	132000.00	46000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	440000.00
210807	Газрын төлбөр		
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	103329.17	73431.43
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6306000.00	54743610.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6306000.00	54743610.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>0.00</b>	<b>2535500.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	0.00	2535500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	2535500.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>19991045.10</b>	<b>60403466.87</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>18550800.00</b>	<b>61955000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>18550800.00</b>	<b>61955000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	18550800.00	61955000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18550800.00	61955000.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-18550800.00	-61955000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1440245.10	-1551533.13
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	159259.68	1599504.78
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1599504.78	47971.65

#### 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,062,388,547.42	1,062,388,547.42
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,062,388,547.42	1,062,388,547.42
C07	Тайлант үеийн үр дүн	-326,941,801.50	-326,941,801.50
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	735,446,745.92	735,446,745.92
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	735,446,745.92	735,446,745.92
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	735,446,745.92	735,446,745.92
D08	Тайлант үеийн үр дүн	51,147,366.39	51,147,366.39
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	786,594,112.31	786,594,112.31

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,599.5	48.0	-1,551.50
Авлага			0.00
Бараа материал	27,988.5	26,848.8	-1,139.70
Үндсэн хөрөнгө	705,858.7	759,697.3	53,838.60
<b>Нийт хөрөнгө</b>	<b>735,446.7</b>	<b>786,594.1</b>	<b>51,147.40</b>
Өр төлбөр			0.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	735,446.7	786,594.1	51,147.40
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>735,446.7</b>	<b>786,594.1</b>	<b>51,147.40</b>

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их буюу алдаа, зөрчилтэй байсан тул хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Аудитаар нийт 110.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 7.0 сая төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулан бүртгэж, 103.9 сая төгрөгийн 2 албан шаардлага өгч мөнгөн хөрөнгийн харилцах данснаас 66.3 сая төгрөгийн шатахууны гүйлгээг И-баримтгүй шилжүүлсэн нь материаллаг зөрчил гэж үзлээ.

##### 5.1 Төлбөрийн акт

Тус байгууллага дээр акт гараагүй.

##### 5.2 Албан шаардлага

###### Илрүүлэлт:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгийн харилцах данснаас 66.3 сая төгрөгийн шатахууны гүйлгээг И-баримтгүй шилжүүлсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн хуулийн заалтууд, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар"-ын 6.5. Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор

баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2. Тайлант онд 37.6 сая төгрөгийн гацуур мод, түүний чимэглэлийг худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй шилжүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-д "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно",10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэсэн заалтууд, Монгол улсын засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" тогтоолыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:**

И баримтгүй гүйлгээ хийсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

**5.3 Зөвлөмж**

Зөвлөмж гараагүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
	1	6,982.0			1	6,982.0	1	6,982.0				
Дүн	1	6,982.0			1	6,982.0	1	6,982.0				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/мянган төгрөгөөр/		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн хөрөнгийн харилцах данснаас 66.3 сая төгрөгийн шатахууны гүйлгээг И-баримтгүй шилжүүлсэн байна.	1	66,337.9			1	66,337.9						

Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант онд 37.6 сая төгрөгийн гацуур мод, түүний чимэглэлийг худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй шууд худалдан авалт хийсэн байна.	1	37,600.0			1	37,600.0					
Дүн	1	103,937.9			1	103,937.9					

Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын Нийтийн тээвэр, гэрэлтүүлэг ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитын асуудлаар Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг шалгахад зөрчил илрээгүй.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

